



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 43

Мандалговь

Үнэлэлт, дүгнэлт өгөх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дах заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванзургаадугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг хэлэлцээд 88,2 хувьтай “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлсүгэй.

2.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д даалгасугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

ДУНДГОВЬ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр

№	№	Зорилт /Бодлогын үндэслэл/	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хариуцагч	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төг/	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин үр дүн			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
										Хүрсэн түвшин	Төсөв /сая төг/	Төсвийн гүйцэтгэл /сая төгрөг/		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	
Бүлэг 1. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО														
Зорилго 1.1. Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэлтийг нэмэгдүүлэх														
1	1.1.1	Дутжүч - ЗДУАХ - 2.1.3.1	Нэгдсэн эмнэлгийн барилгыг ашиглалтад оруулах	2023	ЭМГ	УТХО	10147.3	95	Гүйцэтгэлийн хувиар	100	1527.3	1527.3	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй аймгийн Нэгдсэн эмнэлгийн 100 ортой барилгыг 2023 оны 10 дугаар сард ашиглалтад оруулсан.	100
2	1.1.2	Дутжүч - 2.2.2.2 ЗДУАХ - 2.1.3.1.	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах тоног төхөөрөмж нийлүүлэх	2023	ЭМГ	УТХО	800.0	90.6	Сум өрхийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь	92	146.9	146.9	Япон Улсын Засгийн газраас "Ковид-19 халдварт цар тахлын хямралыг арилгахад яаралтай тусламж үзүүлэх хөтөлбөр"-ийн буцалтгүй тусламжийн хүрээнд 128,5 сая төгрөгөөр 14 ширхэг спирометрийг эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд хуваарилан өгсөн. Өндөршил, Хулд сумын эрүүл мэндийн төвүүд хог хаягдал ангилан ялгах путик, ор, өвчтөний хоолны шкафыг улсын төсвөөр 14,5 сая төгрөгөөр худалдан авсан. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн Сангийн буцалтгүй тусламж 3,9 сая төгрөгийн 35 ширхэг пульсоксиметрийг аймгийн Нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны Нэгдсэн эмнэлэг, өрх сумын эрүүл мэндийн төвүүдэд хуваарилан хүлээлгэн өгсөн. Ингэснээр өрх, сумын эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь 92,0 хувьтай байна.	100
Зорилго 1.2. Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдагчдыг нэмэгдүүлэх														
3	1.2.1	Дутжүч - 3.4.1.4. ЗДУАХ - 2.2.1	Говь-Угтаал сумын спорт заалны барилгын ажлыг үргэлжлүүлэх	2023	ГХБХБГ,	УТХО	1,275.20	45	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	60	275.2	0	Говь-Угтаал сумын спорт заалны барилга угсралтын ажлыг "Бум констакшн" ХХК улсын төсвийн 1,275.0 сая төгрөгийн санхүүжилтээр 2019 оноос эхлэн гүйцэтгэж байна. Барилга угсралтын ажлын явц 55 хувьтай байна. 2023 онд Улсын төсөвт барилгын үлдэгдэл төсөв тусгагдаагүй. Харин ковидын нөхцөл байдлаас шалтгаалан гарсан барилгын материалын үнийн зөрүү буюу 275.2 сая төгрөг тусгагдсан бөгөөд уг хөрөнгөөр дээврийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Барилгын гадна инженерийн шугам сүлжээний зураг төслийг боловсруулан магадлалаар баталгаажуулахаар ажиллаж байна.	66.6
4	1.2.2	Дутжүч - 3.4.1.4. ЗДУАХ - 2.2.1	Олон улсын стандартад нийцсэн усан бассейн бүхий спортын цогцолборын барилгын ажлыг үргэлжлүүлэх	2023	ГХБХБГ,	УТХО	12840.4	35	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	55	4826.8	4826.8	Усан бассейн бүхий спорт цогцолборын барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр "Жи жи ай" ХХК шалгарч 12,840.4 сая төгрөгийн гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд тухайн онд төлөвлөгдсөн 4826.8 сая төгрөгийн гүйцэтгэл 100 хувьтай бөгөөд нийт ажлын явц 55 хувьтай үргэлжилж байна.	100
5	1.2.3		Орон нутагт улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах	2023	НБХ	ОНТ	25.0	0	Хамтран зохион байгуулсан тэмцээний тоо	2	27.8	27.8	U-18 насны Улсын аварга шалгаруулах "3х3" сагсан бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулах ажлын хэсгийг 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, ажилласан. Тус тэмцээний үйл ажиллагаанд нийт 22,444,000 төгрөгийг аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлаас гарган санхүүжүүлсэн. Мөн Олон Улсын хэмжээний мастер, Цагдаагийн хурандаа Ц.Найдангийн нэрэмжит Хөнгөн атлетикийн Ахмад мастеруудын Улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах ажлын хэсгийг 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, ажилласан. Мөн Монголын ширээний теннисний холбоотой хамтран Ширээний теннисний насанд хүрэгчдийн Улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, 12,688,000 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсан. Улс, аймгийн Биений тамир, спортын холбоод болон энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудаас хамтран ажиллах албан хүсэлт ирүүлсний дагуу тэдний үйл ажиллагааг дэмжин, орон нутагтаа спортыг олон төрлөөр хөгжүүлэх зорилгоор энэ онд Улсын аварга шалгаруулах 3 тэмцээнийг зохион байгуулсан. Үүний үр дүнд	100

6	1.2.4	ДутЖүч - 3.4.1.4, ЗДУАХ - 2.2.1	"Шатар" хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх	2023	НБХ	ОНТ	30.0	1	Хамтран зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	19.2	19.2	Аймгийн "Шатар" хөтөлбөрийг энэ онд 3 зорилтын хүрээнд 19 арга хэмжээг нийт 63,147,000 төгрөгийн төсөв зарцуулан хэрэгжүүлэхээр төлөвлөгөө боловсруулан батлуулж, аймгийн Засаг даргын 2023 оны 01/681 албан бичгээр бүх сумдад болон хамтран хэрэгжүүлэх албан байгууллагуудад хүргүүлэн, хэрэгжүүлж байна. Аймгийн аварга шалгаруулах Шатрын тэмцээнийг аймгийн Засаг даргын ивээл дор зохион байгуулж, тэмцээний үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 3,290,400 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мөн "Бүрдийн уянга" хүүхдийн зусланд аймгуудын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга нарын нэрэмжит шилжин явах цомын төлөөх "Говийн бүрд-2023" шатрын нээлттэй тэмцээнийг зохион байгуулж, аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх төсөл арга хэмжээний зардлаас 15,935,000 төгрөгийг гарган санхүүжүүлсэн. Ийнхүү энэ онд дээрх 2 арга хэмжээг аймгийн ИТХ, ГБХЗХГ, БТСГ, аймгийн Шатрын холбоотой хамтран зохион байгуулсан. Үүний үр дүнд ЕБ-ын 14 сургууль дээр шатрын клуб байгуулагдан, нийт 328 хүүхэд шатрын спортоор хичээллэж байна.	100
7	1.2.5		"Бага олимп" наадмыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах	2023	НБХ	ОНТ	40.0	0	Удирдлага, арга зүйгээр хангасан ажлын тоо	1	-	5.5	"Бага олимп - 2023" наадмыг зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2023 оны А/603 дугаар захирамжаар 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан, удирдамжийг боловсруулан батлуулж, бүх сумдын Засаг дарга нарт аймгийн Засаг даргын 2023 оны 01/1312 тоот албан бичгээр хүргүүлж, бэлтгэл ажлыг хангуулсан. Ингээд тус наадмыг 11 дүгээр сарын 10-12-ны өдрүүдэд Мандалговь хотноо зохион байгуулж, нийт 14 сумын 654 тамирчин оролцож, спортын 9 төрлөөр хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө. Багийн нийлбэр дүнгээр Сайнцагаан сумын баг тамирчид тэргүүн байрыг эзэлж, Луус сум, Говь-Угтаал сумын баг тамирчид удаах байранд шалгарч, цом, мөнгөн шагналын эзэд боллоо. Тус наадмыг зохион байгуулахад аймгийн Засаг даргын 2023 оны А/592 дугаар захирамжаар 5.480.000 төгрөгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас гарган зарцуулсан. Энэхүү наадмыг зохион байгуулахад 3 удаа удирдлага, арга зүйгээр ханган ажилласан. Үүний үр дүнд нийтийн биеийн тамираар тогтмол хичээллэгчдийн тоо 30538-д хүрч, энэ онд хүрэх түвшинг 3161-ээр давчлсан.	100
1.3	Зорилго 1.3. Сургалтын чанарын үнэлгээний дунжийг нэмэгдүүлэх													
8	1.3.1	ДутЖүч - 2.1.1.1, ЗДУАХ - 2.3.1.1	Сайнцагаан, Дэлгэрцогт сумын цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулах	2023	ГХБХБГ,	УТХО	5157.3	20	Барилгын ажлын гүйцэтгэлийн дундаж хувь	100	4757.8	4757.8	Сайнцагаан сумын 150 ортой 2 дугаар цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг "Энх баялаг констракшн" ХХК 2,710.0 сая төгрөгийн гэрээ байгуулан 100 хувь гүйцэтгэсэн. Мөн Дэлгэрцогт сумын 150 ортой цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг "Ашид Бюондин" ХХК 2,447,3 сая төгрөгийн гэрээ байгуулан 100 хувь гүйцэтгэсэн бөгөөд Улсын комисс ажиллан ашиглалтад хүлээн аваад байна.	100
9	1.3.2	ДутЖүч - 2.1.2.1, ЗДУАХ - 2.3.2.1	Сайнцагаан сумын Хүмүүнлэг сургуулийн барилгын ажлыг үргэлжлүүлэх	2023	ГХБХБГ,	УТХО	9480.0	5	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	30	3198.6	3198.6	Сайнцагаан сумын Хүмүүнлэг 640 суудалтай сургуулийн барилгын угсралтын ажлыг "Си эйч би жи констракшн" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд 11 дүгээр сарын байдлаар барилгын газар шороо, суурь, каркас, өрлөг, гадна дулааны ажлууд тус тус хийгдсэн. Тухайн онд тусгагдсан төсвийн гүйцэтгэл 100 хувь байна. Нийт ажлын явц 40 хувьтай үргэлжилж байна.	100
10	1.3.3	ДутЖүч - 2.1.2.1, ЗДУАХ - 2.3.2.1	Сайнцагаан сумын Говийн-Ирээдүй сургуулийн барилгын ажлыг үргэлжлүүлэх	2023	ГХБХБГ,	УТХО	5987.9	45	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	80	491.5	491.5	Сайнцагаан сумын Говийн ирээдүй цогцолбор сургуулийн барилгыг 2022 онд буулгаж, 960 суудалтай сургуулийн барилгын угсралтын ажлыг "Си эйч би жи констракшн" ХХК улсын төсвийн 5987.9 төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгэж байна. 2023 онд улсын төсөвт хөрөнгө тусгагдаагүй боловч гүйцэтгэгч компани өөрийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа бөгөөд нийт ажлын явц 80 хувьтай үргэлжилж байна. Ковидын нөхцөл байдлаас шалтгаалан гарсан барилгын материалын үнийн зөрүү буюу 491.5 сая төгрөг 2023 онд тусгагдсан.	100
11	1.3.4	ДутЖүч - ЗДУАХ - 2.3.2.2	Говь-Угтаал сумын сургуулийн дотуур байрны барилгыг ашиглалтад оруулах	2023	ГХБХБГ,	УТХО	1569.8	0	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	94	1409.8	968.2	Говь-Угтаал сумын 80 ортой сургуулийн дотуур байрны барилга угсралтын ажлыг "Есүй ордон" ХХК улсын төсвийн 1,569.8 сая төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгэж байгаа бөгөөд газар шороо, суурь, каркас, өрлөгийн ажлууд хийгдсэн. Ажлын явц 62 хувьтай байна.	65.9

12	1.3.5	Дутжүүч - ЗДУАХ - 2.3.2.6	Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх	2023	ТЗУХ, НБХ	ОНТ	750.0	90	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	92	750.0	363.0	Хүний нөөцийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд 2023 онд аймгийн ИТХ-аас 750,0 сая төгрөгийг батлуулан төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулан төрийн албан хаагчийг мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалт, зөвлөгөөн, орон нутагт дутагдалтай боловсон хүчин бэлтгэх, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах чиглэлээр зохион байгуулан ажиллалаа. 2023 онд хөтөлбөрийн хүрээнд: Төрийн албанд тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллаж байгаа 9 төрийн албан хаагчид гэр, байр орон сууцны дэмжлэг - 77,5 сая төг, Орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр, Шинжлэх ухаан технологийн их сургууль, Хөдөө аж ахуйн их сургууль, Дорноговийн ангаахын сургууль, Их засаг их сургууль, Мандах бүртгэл их сургууль, Глобал удирдагч их сургуульд сурч байгаа 37 оюутантай гэрээ байгуулан боловсон хүчнийг бэлтгэж сургалтын төлбөрийн дэмжлэгт - 42.2 сая төг, Эрүүл мэндийн тусламж дэмжлэг нэн шаардлагатай 3 төрийн албан хаагчид 9 сая төг, Төрийн албан хаагчийн ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3 төрийн албан хаагчийг хамруулж 4.9 сая төг, Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулж 9 сумын ЗДТГ, Тусгай чиг үүргийн 5 байгууллагад 53,4 сая төгрөг, Магистерт суралцаж байгаа 46 төрийн албан хаагчийн сургалтын төлбөрт 40.8 сая төгрөг, дэмжлэгт нэн шаардлагатай төхөөрөмж хэрэгсэл, тоног төхөөрөмж, Төрийн албан хаагчийн чадавхыг бэхжүүлэх сургалтыг 3 удаа зохион байгуулж 48,0 сая төгрөг, Төрийн албан хаагчийг гадаад туршлага судлах ажлын хүрээнд 37 төрийн албан хаагчийг хамруулж 91.0 сая төгрөг, "Боловсролын чанар хүртээмжийг дээшлүүлэх" зорилтын хүрээнд ЕБС-ийн багш, сурагчдын сурч хөгжих, орчин нөхцөлийг сайжруулах зорилтын хүрээнд 1238 багш, сурагчийг хамруулан 296.2 сая төгрөг, нийт 661.1 сая төгрөгийг зарцуулаад байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 3 дугаар улирлын байдлаар 93%-тай байна. Үүний үр дүнд Боловсон хүчний хангалт 64.9% - 78 % хүрсэн. 151 албан хаагчийн ажиллах орчин нөхцөл сайжирсан. Аймгийн хэмжээнд 9 төрийн албан хаагчийн амьдах орчин нөхцөл сайжирч байр орон сууц болон гэртэй болсон.	100
13	1.3.6		Засгийн газар болон аймгийн захиалгаар дотоод, гадаадад суралцагчидтай гэрээ хийж, орон нутагт нэн шаардлагатай боловсон хүчин бэлтгэх	2023	ТЗУХ	ОНТ	750.0	35	Гэрээ байгуулсан оюутны тоо	35	750.0	363.0	2023-2024 оны хичээлийн жилд орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр суралцаж байгаа 3,4-р дамжаанд суралцаж байгаа 37 оюутан сурагчидтай гэрээ байгуулан 42.2 сая төгрөгийн сургалтын төлбөрийн тэтгэлэгт хамруулан бэлтгээд байна.	100
Зорилго 1.4. Хүн амын бүлгүүдийн онцлог хэрэгцээнд нийцсэн хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх														
14	1.4.1		Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилгыг ашиглалтад оруулах	2023	ХХҮГ	Гадаадын хөрөнгө оруулалт	300.0	95	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	100	300.0	300.0	Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хамтарсан "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах" төслийн хүрээнд Дундговь аймгийн Сайнцагаан суманд 3.3 тэрбум төгрөгийн баригдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилгыг улсын комисс хүлээн авсан бөгөөд 2023 оны 9 дүгээр сарын 11-ны өдөр нээлтээ хийж, 20 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлээд байна. Одоогоор хөгжлийн бэрхшээлтэй 15 хүүхдийг сэргээн засах үйлчилгээнд хамруулж, асран хамгаалагч нарт сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. Мөн төвийнхөө үйл ажиллагааг 10 аж ахуйн нэгж, төрийн байгууллагад танилцууллаа.	100

15	1.4.2	Дутжүүч - ЗДУАХ - 2.4.2.1.5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд арга хэмжээ зохион байгуулах	2023	НБХ	ОНТ	5.0	1	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	5.0	14.1	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 3 зорилт 11 арга хэмжээтэй 2023 оны төлөвлөгөөг батлуулж дараах арга хэмжээг зохион байгууллаа. -Аймгийн салбар зөвлөлөөс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дунд бичгийн спортыг сурталчлах зорилгоор "Бочигийн аймгийн аварга шалгаруулах" тэмцээн зохион байгуулж, шагналт байранд шалгарсан тамирчид нийслэлийн аварга шалгаруулах бочигийн тэмцээнд 4-р байр, Монголын хүүхдийн спортын VII наадам, Хан-Уул дүүргийн тэмцээнд хүрэл медаль авсан амжилтыг үзүүлсэн. -Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны төлөөлөл Дундговь аймагт ажиллаж хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй уулзалт хийж тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан саналын дагуу аймгийн төвийн гэрлэн дохионд хараагүй иргэний дуут дохиог байрлуулсан. -Хараагүйчүүдийн үндэсний холбооноос харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд зохион байгуулсан компьютерын түргэвчилсэн 7 хоногийн сургалтад ерөнхий боловсролын сургуулийн 1 хүүхдийг хамруулсан. - Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний орон тооны бус зөвлөл, аймгийн засаг даргын тамгын газраас Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн спортын VII-р тэмцээн наадамд оролцох 4 хөгжлийн бэрхшээлтэй иргэний зардлыг шийдвэрлэснээр тэмцээнд оролцох боломжийг бүрдүүлсэн.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн баруун бүсийн чуулга уулзалт зохион байгуулсан.Тус бага чуулганд Сайнцагаан, Дэлгэрцогт, Дэлгэрхангай,Хулд,Эрдэнэдалай сумдын хөгжлийн бэрхшээлтэй 63 иргэн оролцож, сургалт мэдээлэл, хэлэлцүүлэгт хамрагдлаа.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд спортын уралдаан	100
Зорилго 1.5. Иргэдийг соён гэгээрүүлэх, монгол өв соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоог нэмэгдүүлэх														
16	1.5.1	Дутжүүч - 1.1.1.1, ЗДУАХ - 2.5.1.1	Төв Халхын Дуулалт Жүжгийн Театрын барилгын ажлыг үргэлжлүүлэх	2023	ГХБХБГ,	УТХО	10543.7	10	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	20	741.7	70.0	Соёлын яамнаас 2 удаа цахим хэлэлцүүлэг зохион байгуулж, ТХДЖТ барилгын ажлыг хуучин суурь дээр үргэлжлүүлэн барих, зураг төсвийг дахин шинэчлэн боловсруулахад шаардгдах 70.0 сая төгрөгийг аймгийн ОНХС-ийн санхүүжилтээр шийдвэрлэлээ. Шинэчилсэн зураг төсвөөр 2024 оны УТХО-нд батлуулахаар санал явуулаад байна.	0
17	1.5.2	Дутжүүч - ЗДУАХ - 2.5.1.4	Дэлгэрцогт, Цагаандэлгэр сумдын соёлын төвийн барилгыг ашиглалтад оруулах	2023	ГХБХБГ,	УТХО	2952.6	70.5	Барилга ажлын гүйцэтгэлийн хувь	100	1489.0	1489.0	Цагаандэлгэр сумын 240 суудалтай соёлын төвийн барилгын ажлын гүйцэтгэгч "Хэрмээдэй" ХХК, төсөвт өртөг нь 1,523.4 сая төгрөг, тайлант хугацаанд гүйцэтгэлээр 709,669.1 мянган төгрөгийн санхүүжилт олгогдсон. Гадна, дотор заслын ажлууд хийгдээгүй үлдсэн. Барилгын ажлын гүйцэтгэл 70 хувьтай. Тус барилгын гадна инженерийн шугам сүлжээний зураг төсвийг боловсруулж, магадлалаар баталгаажуулан, хөрөнгө оруулалтыг 2024 оны улсын төсөвт тусгуулсан. Дэлгэрцогт сумын 250 суудалтай соёлын төвийн барилгын угсралтын ажлыг "Одда тайж" ХХК 1,429.25 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд ажлын явц 85 хувьтай, гадна, дотор заслын ажлууд хийгдэж байгааг 2023 оны 07 дугаар сард зогссон.	23.7
2	Бүлэг 2. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО													
2.1	Зорилго 1. 2020 онд гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээний 37.84 хувийг орон нутгийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангаж байсныг 2024 онд 56-аас доошгүй хувьд хүргэнэ.													

18	2.1.1	4.1.1.3, ЗДУАХ - 3.3.1.4.	Чадамжид суурилсан техник технологийн шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үр ашгийг нэмэгдүүлэх "Шинэ хөдөө" төслийг хэрэгжүүлэх	2023	АЗДТГ	УТХО	1000.0	30	Шинээр бий болсон хөдөө аж ахуйн техникийн тоо	50	297.8	506.3	"Шинэ хөдөө" төслийн хүрээнд хонь хяргах машин-30, ноос прэслэгч-5, малын хашаа-80, явуулын мал угаалгын ванн-5, явуулын футика-5, подон-150, шүршүүрийн вандан-10 тус тус хүлээн авч Луус, Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Дэлгэрцогт, Гурвансайхан сумдад, 79.0 сая төгрөгний өртөгтэй арьс элдэх иж бүрэн тоног төхөөрөмж, оёдлын машины хамт Эрдэнэдалай суманд, 15 суманд газар тариалангийн зориулалтаар 297,7 сая төгрөгний 13 төрлийн тоног төхөөрөмж болон хүлэмжийг хүлээлгэн өгсөн. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Луус суманд 49.5 сая төгрөгний өртөгтэй газар тариалангийн зориулалттай 50 морины хүчтэй трактор, Хүнс, хөдөө аж ахуйн газарт 80 сая төгрөгний өртөгтэй 50 морины хүчтэй трактор 4 дагалдах хэрэгслийн хамт олгож газар тариалан эрхлэгчдийг дэмжиж хамтарч ажиллаж байна. Ингэснээр нийт хөдөө аж ахуйн чиглэлээр 8 нэр төрлийн 290 ширхэг тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, газар тариалангийн чиглэлээр 2 нэр төрлийн 19 хүлэмж, тоног төхөөрөмжийг хүлээн авсан.	100
19	2.1.2	4.1.1.3, ЗДУАХ - 3.3.1.4.	Эдийн засгийн үр ашиг бүхий ажлын байр шинээр бий болгох инновацид суурилсан жижиг дунд үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, санхүүгийн бодлогоор дэмжих	2023	АЗДТГ, ХХААГ	ЖДҮХС	500.0	3	Шинээр байгуулагдсан үйлдвэрийн тоо	2	500.0	332.6	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас Сайхан-Овоо сумын "Эрхэст Ундраа" ХХК Мал, төхөөрч мах, махан бүтээгдэхүүн ангилж савлах чиглэлээр 242,64 сая төгрөг, Сайнцагаан сумын Дэлгэр "Номт-Ундраа" ХХК Мах махан бүтээгдэхүүн ангилж савлах чиглэлээр 90.0 сая төгрөгний санхүүжилт тус тус авч үйлдвэр байгуулан, Мах, махан бүтээгдэхүүн ангилж савлах чиглэлээр үйл ажиллагааг эхүүлээд байна.	100
	2.1.3			2023	АЗДТГ, ХХААГ	ЖДҮХС	200	-	Дэмжлэгт хамрагдсан үйлдвэр, цехийн тоо	1	0	0	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас Сайхан-Овоо сумын "Эрхэст Ундраа" ХХК Мал, төхөөрч мах, махан бүтээгдэхүүн ангилж савлах чиглэлээр 242,64 сая төгрөг, Сайнцагаан сумын Дэлгэр "Номт-Ундраа" ХХК Мах махан бүтээгдэхүүн ангилж савлах чиглэлээр дээрх 2 ААН-ийг нийт 332.64 сая төгрөгний санхүүгийн дэмжлэгт хамруулсан.	
20	2.1.4	8.3.1.3, ЗДУАХ - 3.3.1.7.	Ноос, ноолуур, арьс ширний анхан шатны үйлдвэр, цехийг байгуулах	2023	ХХААГ	ХЭДС	20.0	3	Байгуулагдсан үйлдвэр цехийн тоо	3	20.0	30.0	Сайнцагаан, Адаацаг, Өндөршил суманд ХХСан болон ХЭДСангаас 30.0 сая төгрөгний хөнгөлөлттэй зээлд хамрагдан арьс, нэхий элдэх анхан шатны цех 3 байгуулагдсан. Хадгалагдсан 3, шинээр 3 ажлын байр бий болсон. Эдгээр 3 цех нь нийт 360 ширхэг нэхий элдэн 10,8 сая төгрөгний борлуулалтын орлоготой ажилласан.	100
2.2 Аялал жуулчлал														
21	2.2.1	8.2.1.1, ЗДУАХ - 3.4.1.2	Байгаль, түүх, соёлын аялал жуулчлалын эвент арга хэмжээг зохион байгуулах	2023	ХБТХОХ	УТ, ОНТ	100.0	2	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	4	100.0	70.5	Хулд суманд 01 дүгээр сарын 27-ны өдөр "ТЭМЭЭНИЙ ӨВ СОЁЛ" өвлийн эвент арга хэмжээг зохион байгуулж, Өмнөговь аймгийн 7 сум, Дундговь аймгийн 3 сумын тэмээчид оролцож, гадаад, дотоодын 518 жуулчид үзэж, сонирхсон. Цагаан суварга дахь "Говь каравансерай" жуулчны баазтай хамтран "Сэтгэшгүй оддын чуулган" арга хэмжээг зохион байгуулж 165 аялагч, жуулчид үзэж сонирхсон. Дуу хуур, өв, соёлын өлгий нутгийн бренд болсон Уяхан замбуу тивийн наран урлагийн их наадмыг "Их газрын чулуу" байгалийн цогцолбор газарт зохион байгуулж 15 сумын 3200 морин хуурч, уртын дуучид оролцож, зохион байгуулах багийн 1000 хүн, гадаад, дотоодын 41000 хүн үзэж сонирхсон. Адаацаг сумын Сүм хөх бүрд байгалийн үзэсгэлэнт газарт "Адуучны өв соёлын баяр" эвент арга хэмжээг зохион байгуулж 4 аймгийн 72 адуучин залуус оролцож, 900 гаруй зочид төлөөлөгчид үзэж сонирхсон. Нийт 4 арга хэмжээнд 42583 гадаад, дотоодын жуулчид үзэж сонирхсон. Улсын төсвийн 10.0 сая төгрөг, орон нутгийн төсвийн 30.0 сая төгрөг зарцуулсан.	100
				22				2.2.2	2023	Ай Ти Эм олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд нэгдсэн байдлаар зохион байгуулах	8	Оролцсон аж ахуйн нэгжийн тоо	10	

23	2.2.3		Цахим технологид суурилсан аялал жуулчлалын гадаад, дотоод сурталчилгааг өргөжүүлэх, "Dundgovi"	2023			0	Хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо	96		12.0	12.0	Айхотел ХХК-тай гэрээ байгуулж "Dundgovi" аялал жуулчлал, бизнес эрхлэлтийг дэмжсэн гар утасны апплейкешн, платформыг 2 удаа хэлэлцүүлж хүлээж авсан. Цахим платформд 96 аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэл орж, 204 иргэн гар утсанд татаж суулгасан. Орон нутгийн төсвийн 12.0 сая төгрөгийг зарцуулав.	100
2.3 Эрчим хүч														
24	2.3.1	ДутЖҮЧ - 4.2.2.3, ЗДУАХ - 3.5.1.2	Аймгийн төвийн дулааны станцын ажлыг эхлүүлэх	2023	ХБТХОХ	Гадаадын зээл тусламж	25,175.0	5	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	50	11,538.5	11,538.5	Дундговь аймгийн төвд шинээр баригдаж байгаа дулааны станцын ажлыг 2023 оны 4 дүгээр сарын 15 -аас эхлүүлэн зуухны суурийн цутгалт 100%, зуух 1, 2-ын угсралт 80%, нүүрс хүлээн авах конвейрын суурийн цутгалт 40%, утаа сорогч, конвейрын барилгын суурийн ажил 20%-тай хийгдэж, нийт ажлын гүйцэтгэл 36 хувьтай байна.	68.8
25	2.3.2	ДутЖҮЧ - 4.2.2.3, ЗДУАХ - 3.5.1.4.	Аймгийн төвийн 220/110/35 кВ "Мандал" дэд станцын өргөтгөлийн ажлыг	2023	ХБТХОХ	УТХО	68.3	90	Ажлын гүйцэтгэлийн хувь	100	68.3	68.3	Говийн бүсийн салбарын 220/110/35 кВ "Мандал" дэд станцын өргөтгөлийн ажлыг 2023 онд 100 хувь хийж дуусгасан.	100
2.4. Аймгийн тээвэр, мэдээлэл, холбооны салбар														
26	2.4.1	ДутЖҮЧ - ЗДУАХ - 3.6.1.2	Арвайхээр-Мандалговь Чойр чиглэлийн авто замын ажилд анхаарч хамтран ажиллах	2023	ХБТХОХ	УТХО	2000.0	0	Холбогдох байгууллагатай хамтарч ажилласан эсэх	1	0.0	0.0	Ерөнхий сайдыг Дундговь аймагт ажиллах үеэр хэвтээ тэнхлэгийн авто замын асуудлыг эхлүүлэхээр санал тавьж хамтран ажиллаж байна. Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн авто зам Чойр-Мандалговь чиглэлээс 2024 оны УТХО-д хэрэгжихээр тусгагдаж байна.	100
27	2.4.2	ДутЖҮЧ - 8.1.1.5, ЗДУАХ - 3.6.1.4	Мандалговь-Улаанбаатар, Мандалговь-Даланзадгад чиглэлийн Улсын чанартай хатуу хучилттай авто замын арчилгаа, засварын ажилд хяналт тавьж, орон нутгийн авто замын засвар, арчилгааны хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх	2023	ХБТХОХ	УТХО ОНТ	6200.0 800.0	1	Авто замын засварын ажилд хяналт тавьсан тоо	2	11,500.0	11,900.0	2023 онд Мандалговь-УБ чиглэлийн авто замын урсгал засварт Дундговь авто зам засварыг гүйцэтгэх 1050.0 сая, Улсын төсвөөс 193-198 км хатуу хучилттай авто замын арчилгааны бүрэн засвар хийгдэх 3.7 тэрбум, Мандалговь-Даланзадгад чиглэлийн авто замын урсгал засварт Дундговь авто зам засвар арчилгаа хийх 950.0 сая, Улсын төсвөөс 14-19 км замд бүрэн засвар хийгдэх 3.4 тэрбум, 19-23км замд бүрэн засвар хийгдэх 2.8 тэрбум төгрөг тус тус батлагдаад нийт 11.9 тэрбум төгрөгийн зам, замын байгууламжийн засвар, арчилгаа хийгдэж улсын комисс хүлээн аваад байна. Дээрх засварын ажлын гүйцэтгэлийн явцад 3 удаагийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв.	100
3.3	Бүлэг 3.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО													
3.1	Зорилго 1. Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний хүртээмжийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх													
3.1	3.1 Цахим Монгол- төрийн шуурхай үйлчилгээ													
28	3.1.1	ДутЖҮЧ- 5.3.1.1 ЗДУАХ - 4.1.1	"Цахим төр- Ухаалаг Дундговь" цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх	2023	ТЗУХ	ОНТ	100.0	80	Цахим шилжилтийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90	2.8	2.8	Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын удирдлагуудыг албан тушаалын тоон гарын үсэгтэй болгож, төрийн байгууллагуудыг 100 хувь албан бичиг солилцооны дундын системд холбосноор албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг цахимжуулсан. Аймгийн төрийн байгууллагуудын нэгдсэн цахим хуудсыг шинэчлэн, бүх сумдыг шинээр цахим хуудастай болгож, нийтийн мэдээллийн тухай хуулийн хүрээнд 98 төрлийн мэдээллийг ил болгосноор цахим мэдээллийн ил тод байдал 88.8 хувь хүрсэн.Боловсролыг дэмжих жилийн ажлын хүрээнд 2023 онд жил танхимаар 250, цахимаар 360 нийт 610 төрийн албан хаагчдад цахим ур чадварын сургалтыг зохион байгуулсан.2200 иргэд, төрийн албан хаагчдад цахимаар алсын хараа 2050 урт хугацааны бодлогын цахим контент сургалтыг Удирдлагын академитай хамтран зохион байгуулж гэрчилгээ олгосон.Иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр цахим болон танхимын 36 удаагийн сургалтыг 1800 гаруй иргэд, төрийн албан хаагчдыг хамруулсан. Цахим шилжилтийн үйл ажиллагааг, сум, байгууллагын хамтран ажиллах гэрээнд тусган хэрэгжүүлэн ажилласнаар хэрэгжилтийн хувь 70 хувьтай байна. Аймгийн төвд төрийн цахим үйлчилгээний "ХУРДАН" гурван цэгийг байгуулж, компьютер техник хэрэгсэл, тавилга тоног төхөөрөмжөөр хангаж 530 төрлийн цахим үйлчилгээг иргэдэд хүргэж ажиллаж байна. Цахим шилжилтийн төлөвлөгөөний хэрэгжилт 87 хувьтай байна.	70
3.2	Зорилго 3.2. Хууль сахиулах байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлж, гэмт хэргийн шийдвэрлэлтийн хувийг нэмэгдүүлэх													

29	3.2.1	ЗДҮАХ - 4.3.1	Түр Хамгаалах байртай болох	2023	ГБХЗХГ ЦГ	ОНТ	250.0	0	Түр хамгаалах байртай болсон эсэх /тгйм-1, үгүй-0/	1	250.0	125.0	Аймгийн 2023 оны төсөвт хүүхэд хамгаалал болон хүчирхийллийн чиглэлээр 250,0 сая төгрөгийн төсөвтэй "Түр хамгаалах байр"-ны хөрөнгийг шийдвэрлүүлэн ажлын гүйцэтгэгчээр "Зууны гүүр" ХХК-нийг сонгон шалгаруулан, тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд улсын комисст хүлээлгэн өгөхөд бэлэн болоод байна.	100
30	3.2.3	ЗДҮАХ - 4.3.1	Камержуулалтын системийн зураг төсөв боловсруулах	2023	ЦГ	ОНТ	30.0	0	Батлагдсан зураг төсөв боловсруулсан эсэх	1	30.0	30.0	Аймгийн төвийн нэгдсэн камержуулалтын зураг төсвийг боловсруулан хүлээн аваад байгаа бөгөөд 2024 оны аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр үе шаттайгаар хэрэгжүүлэхээр ажиллаж байна.	100
Бүлэг 4.НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО														
Зорилго 4.1. Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, хамгаалах, нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлнэ.														
31	4.1.1	ДуАТЖУЧ-6.2.2.1 ЗДҮАХ - 5.1.4.1	"Дундговio нoгoоpуулья" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх	2023	БOАЖГ	ОНТ	100.0	83	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	84.6	118.0	63.8	"Тэрбум" мод үндэсний хөдөлгөөн, "Дундговio нoгoоpуулья" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд аймгийн ИТХурлын тогтоолоор 2023 онд 100.0 сая төгрөг батлуулсан. Хөтөлбөрөөс нoгoон байгууламжийн усалгаа арчилгаанд зориулж 1 гүн өрмийн худаг гаргаж, улсын чанартай авто зам дагуу тарьсан модны хашаа хамгаалалтыг 10046 метр урт тороор шинэчлэн, алмны модны 60 ширхэг суулгац, цэцгийн мандлыг 140 м2 талбайд тарих зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн. Ховд аймгийн Булган сумын тариаланч Х.Балжинням, С. Ариунбаатар, "Ногоон-Ази" ТББайгууллагатай хамтран "Алимны мод тариалах арга зүйн сургалт", "Мод ногоон байгууламжийн үрсэлгээ, арчилгаа, усалгаа хийх тарих, арчлах сургалт, Хүнс хөдөө аж ахуй хүнсний ногоо, хүлэмжийн бизнесийн ирээдүйн чиг хандлага, ирээдүйн чиг хандлага ашигт ажиллагааг нэмэгдүүлэх гарц-япон орны туршлагаас сургалтыг нийт 230 хүнд зохион байгуулан нийт 63.8 сая төгрөгийг зарцуулав.Төлөвлөгөөний хэрэгжилт 94.4 хувьтай хэрэгжив.	100
32	4.1.2		Орон нутгийн хөрсөнд дасан зохицсон тарьц, суулгац бэлтгэх мод үржүүлгийн газар шинээр байгуулах	2023	БOАЖГ		УТ	250.0	1	Шинээр байгуулсан мод үржүүлгийн газрын тоо	1	250.0	250.0	Дэлгэрцогт, Хулд, Баянжаргалан сумд нийт 11 га-д мод үржүүлгийн газар байгуулахаар газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган батлуулсан.Сайнцагаан сумын 4-р багийн нутагт 3 га газарт Жимс, жимсгэнийн суулгац үржүүлгийн төвийг байгуулж хамгаалалтын зурваст улиас, хайлаас зэрэг 875 мод, жимс, жимсгэнийн суулгац 7 төрлийн 1500, нийт 2375 ширхэг мод, сөөгийг тарьж дуслын усалгааны системд холбож цэнэг усалгаа хийв.
33	4.1.3	ДуАТЖУЧ-6.2.2.2 ЗДҮАХ - 5.1.4.2	Аймгийн хэмжээнд 4 га талбайд ойн зурвас байгуулах	2023	БOАЖГ	УТ	76	6	Тухайн жилд байгуулсан ойн зурвасын талбайн хэмжээ	45	76.0	76.0	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн "Дундговio нoгoоpуулья" хөтөлбөрийн хүрээнд "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-өөр 141 аж ахуйн нэгж, байгууллагын 1284 иргэн 99944 мод, сөөг тарьж арчилгаа, усалгаа хийв. Улс, орон нутгийн хөрөнгөөр ойн зурвас 18 га, зам дагуу 25 га, хувийн хэвшил 2 га нийт 45 га талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлэв.	100
Бүлэг 5. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО														
Зорилго 5.1. Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн орон сууцаар хангах														
34	5.1.1	ЗДҮАХ - 6.1.1.1	Луус суманд усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн ажлыг үргэлжлүүлэх	2023	ХБТХОХ	УТХО	3995	26.2	Шугам сүлжээнд холбогдсон сумын барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	52.3	1043.7	1043.7	Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны багцад тус аймгийн Луус сумын төвийн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн угсралтын ажлын 1,0 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд тухайн оны төсвийн гүйцэтгэл 100 хувьтай бөгөөд нийт барилга угсралтын ажлын гүйцэтгэл 52.3 хувьтай байна.	100
35	5.1.2	ДуАТЖУЧ-8.1.1.2 ЗДҮАХ - 6.1.1.2	Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумдыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болгох	2023	ХБТХОХ	ОНТ	100.0	13	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болсон сумдын тоо	2	200.0	140.0	Цагаандэлгэр сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг Сонголт дизайн ХХК-тай 98,8 сая төгрөгөөр байгуулсан ажлын явц 50 хувьтай хийгдэж байна. Эрдэнэдалай сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хүлээн аваад байна.	50
36	5.1.3	ДуАТЖУЧ-3.2.1.1 ЗДҮАХ - 6.1.1.3	Аймгийн төвийн "Түмний хороолол", "Хаус хорооллын"-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах	2023	ХБТХОХ	ОНТ	100.0	0	Хүлээн авсан ерөнхий төлөвлөгөөний тоо	2	100.0	100.0	"Түмний хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний ажлын зураг төсөв боловсруулах" зөвлөх үйлчилгээг Бес онцгой дизайн ХХК 50.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэж байна. Хаус хороололын ерөнхий төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг Сонголт дизайн ХХК-тай 49,5 сая төгрөгөөр байгуулсан бөгөөд тус 2 төлөвлөгөөг хүлээн аваад байна.	100

37	5.1.4	ДуАТЖУЧ-8.1.1.3. ЗДҮАХ - 6.1.1.4	Жишиг гудамж төсөл, тохижилтын ажлын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх	2023	ХБТХОХ	ОНТ	1000.0	1	Хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн эсэх /Тийм-1, үгүй-0/	1	800.0	800.0	2023 онд хөрөнгө шийдэгдээгүй	0
38	5.1.5	ЗДҮАХ - 6.1.1.5	Эрдэнэдалай сумын 2 км хатуу хучилттай авто замыг ашиглалтад оруулах	2023	ХБТХОХ	УТХО	334.2	84	Гүйцэтгэлийн хувь	100	334.2	334.2	2023 онд ямар ажил хийгдээгүй бөгөөд улсын төсөвт батлагдсан үнийн өсөлтийн зөрүүг гүйцэтгэгчид олгосон бөгөөд гүйцэтгэгчийг хуулийн байгууллагад өгөхөөр ажиллаж байна.	0
39	5.1.6		Сайнцагаан сумын Нийтийн халуун усны засвар хийх	2023	ХБТХОХ	ОНТ	300	0	Засварын ажлын гүйцэтгэлийн хувь	70	300	104.4	Тус ажлын худалдан авах ажиллагааг 2 удаа зарласан ч амжилтгүй болсон тул Елбата ХХК-тай 299.0 сая төгрөгийн шууд гэрээ байгуулсан. Ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна.	70
НЭГ ТГЭ -	хэрэгжилтийн хувь 100 хувь-29, 70 хувь-2, 68.8 хувь-1, 66.6 хувь-1 65.9 хувь-1, 50 хувь -1, 23.7-1, 0-хувь 3												85	

БАТАЛГААЖУУЛСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

ХЭРЭГЖИЛТ ТООЦСОН:

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХБТХОХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



Ц.МӨНХБАТ

Ж.УЯНГА

Л.МЯГМАРМЯДАГ